

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНИЙН ХЭЛЭХ ҮГ

Хятадын Коммунист Намын Төв хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Эрхэмсэг ноён Ши Жиньпин Танд болон Хятадын Коммунист Нам ба дэлхийн улс төрийн намуудын дээд түвшний яриа хэлэлцээнд оролцогч эрхэм хүндэт зочид, төлөөлөгчид өө, Улс төрийн намуудын удирдлагууд аа:

Юуны өмнө, Монгол Улсын уул усаар холбогдсон мөнхийн хөрш БНХАУ-ын Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал болон Бүх Хятадын Ардын улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн чуулганууд амжилттай зохион байгуулагдаж, эрхэмсэг ноён Ши Жиньпин БНХАУ-ын Даргаар улиран сонгогдож, Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайдаар Ли Чян томилогдож, төр, засгийн шинэ удирдлагын баг үүрэгт ажилдаа орж буйд Монголын нийт ард түмнийг төлөөлж, Монгол Ардын намыг төлөөлж чин сэтгэлийн халуун баяр хүргэж, ажлын амжилт хүсье.

Ши Жиньпин Таны удирдлагын дор БНХАУ чинээлэг, хүчирхэг, ардчилсан, соёлжсон, эв найрамдалтай, үзэсгэлэнтэй бөгөөд орчин үеийн аугаа социалист улсыг бүх талаар цогцлон байгуулах “хоёр 100 жил”-ийн зорилтоо амжилттай хэрэгжүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

Олон улсын геополитикийн харилцаа зөрчилт хямралд орж, шинэ тутам олон сорилттой тулгарч буй энэ үед БНХАУ-ын дэвшүүлсэн “Даян дэлхийн хөгжлийн санаачилга”, “Дэлхийн аюулгүй байдлын санаачилга”, “Даян дэлхийн соёл иргэншлийн санаачилга” зэрэг уриалгуудын хүрээнд улс орнууд эрх тэгш, энх тайвнаар зэрэгцэн орших, тулгамдсан асуудлуудыг яриа хэлэлцээ, зөвшилцлийн арга замаар шийдвэрлэх саналыг Монголын тал бүрэн дэмжиж байна.

Харилцан итгэлцэл, яриа хэлэлцээ, хамтын ажиллагаа бол даян дэлхий энх тайван байхын, хүн төрөлхтөн аз жаргалтай, сэтгэл хангалуун байж, улс орнууд хөгжин цэцэглэхийн хамгийн чухал баталгаа билээ.

Улс төрийн намууд бол төр ба иргэдийн итгэлцлийн гүүр юм. Тийм ч учраас улс төрийн намуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол нь улс орнуудын найрсаг дипломат харилцааны түлхүүр асуудал билээ.

Дэлхийн улс төр, эдийн засгийн гол бодлого тодорхойлогчдын нэг БНХАУ-ын Хятадын Коммунист Нам дэлхийн бусад улс орны улс төрийн намуудын дээд хэмжээний яриа хэлэлцээрийг санаачлан зохион байгуулж байгаа нь туйлын цаг үеэ олсон арга хэмжээ бөгөөд даян дэлхийн энх тайвны төлөөх үйлсэд оруулж буй чухал хувь нэмэр, орчин үеийн шинэчлэлийн олон талт дуу хоолойг илэрхийлэх боломж бүхий үзэл бодлын чөлөөт индрийг бүрдүүлж байгаад талархаж, онцлон тэмдэглэж байна.

Эрхэмсэг хатагтай ноёд оо, эрхэм журмын нөхөд өө,

Монгол Улс нь “Бүс ба Зам” санаачилгыг анхнаасаа дэмжиж ирсэн бөгөөд цаашид ч бүс нутгийн тогтвортой хөгжлийн төлөө Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд нийгэм, эдийн засгийн томоохон төслүүдэд харилцан ашигтай түншлэн ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлье.

Дэлхий нийтэд тулгамдаж буй уур амьсгалын өөрчлөлт, байгаль экологийн тэнцвэрт бус хөгжил, эдийн засгийн тэгш бус байдал, ядуурал, мөргөлдөөн, хямралт байдал зэрэг асуудлыг улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлалын хүрээнд нэгдмэл санаа зорилготойгоор хамтран шийдвэрлэх нь Та бидний энэ цаг үеийн түүхэн үүрэг билээ.

Дэлхийн хоёрдугаар дайны дараахь үзэл суртлын хуваагдал, Хүйтэн дайны уршиг хагас зуун жил үргэлжилж, хүн төрөлхтөний хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлснийг бид мартаж учиргүй.

Улс орон бүхэн бие биенийхээ тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, сонгосон хөгжлийн зам, үзэл бодлын болон засаглалын ялгааг хүндэтгэн үзэж, даян дэлхийг энх тайван байлгаж, хүн төрөлхтөнийг аз жаргалтай амьдрах суурь нөхцөл байдлыг бүрдүүлэхэд энд хуран цугларсан улс төрийн намууд, ялангуяа, энэхүү чуулганыг санаачлан зохион байгуулж буй Хятадын Коммунист Нам түүхэн үүрэг гүйцэтгэж чадна гэдэгт итгэж байна. Ши Жиньпин даргын сая хэлсэнчлэн “Бусдын гэрлийг унтрааснаар өөрийгөө илүү гэрэлтүүлж чадахгүй, бусдын замыг хааснаар хол явж чадахгүй гэдэгтэй санал нэг байна. Дэлхийн улс орнууд хамтдаа энх тайвнаар зэрэгцэн оршиж байж олон өнгийн цэцгэс ургасан үзэсгэлэнт дэлхийг бүтээх боломжтой гэдэгтэй ч санал нэг байна.

102 жилийн түүхтэй Ази тивийн улс төрийн анхны намуудын нэг Монгол Ардын Намын хувьд “Орчин үеийн шинэчлэлийг гүнзгийрүүлэхэд улс төрийн намуудын үүрэг хариуцлага” уриан дор зохион байгуулагдаж буй Хятадын Коммунист Нам ба дэлхийн улс төрийн намуудын дээд хэмжээний яриа хэлэлцээнээс гарах шийдвэрүүдийг идэвхтэй дэмжиж, хамтран ажиллах болно.

Эрхэмсэг ноён Ши Жиньпин Танд ажлын амжилт хүсч, Монгол Ардын Намын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын хувьд ойрын хугацаанд БНХАУ-д хийх албан ёсны айлчлалын үеэр дахин уулзаж, хоёр улсын Иж бүрэн стратегийн түншлэлийг шинэ агуулгаар баяжуулах талаар дэлгэрэнгүй санал солилцоно гэдэгт итгэлтэй байна.

Энд цугларсан улс төрийн намуудын бүх удирдлагууд та бүхэнтэй Монгол Ардын нам, Монгол Улс болон Монгол Улсын Засгийн газар нээлттэй, харилцан итгэлцэлтэй түншлэн ажиллахад бэлэн байгаа гэдгээ дахинэ илэрхийлье.

Чуулганы үйл ажиллагаанд амжилт хүсье.